

ХЭВЛЭН НИЙТЛЭХ ШААРДЛАГА

2023 оны дугаараас эхлэн зөвхөн хэл шинжлэл, утга зохиолын чиглэлээр бичсэн өгүүлийг хэвлэн нийтэлнэ.

Өгүүлийн бүтэц:

ХУРААНГУЙ (150-200 үгэнд багтааж англи хэлээр бичих)

ТҮЛХҮҮР ҮГ (8 хүртэл үг, хэллэгийг нэр үг, ганц тооны хэлбэрээр бичнэ)

1. УДИРТГАЛ

1.1. судалгааны зорилго

1.2. судалгааны арга

1.3. судалгааны хэрэглэгдэхүүн

2. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН (ХЭЛЭЛЦҮҮЛЭГ)

4. ДҮГНЭЛТ

5. НОМЗҮЙ гэсэн үндсэн хэсэгтэй байна. Мөн шаардлагатай бол ТАЛАРХАЛ, ХАВСРАЛТ байж болно.

Өгүүлийн нэрийг том үсгээр, тод хараар бичиж, нэг мөрийн доор баруун гар талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажлын газрын нэрийг бичнэ. Өгүүлийн нэрийн англи орчуулга, зохиогчийн нэрийн латин бичлэгийг зүүлтэд бичнэ.

Хүснэгт, график, зураг оруулбал дугаарлаж, тайлбарыг доор нь голлуулж налуу үсгээр бичнэ. Мөн хэвлэлийн чанар хангахуйц, зохиогчийн эрхийн зөрчилгүй байхыг анхаарна уу.

Өгүүлийн хэлбэр:

Цаасны хэмжээ: А4, хуудасны тоо 8-15 байна. (А4, 8 х. = 1 х.х.)

Бичвэрийн хэмжээ: цаасны дээд, доод талаас 20 мм, баруун талаас 30 мм, зүүн талаас 15 мм)

Үсгийн хэлбэр: Times New Roman тиг, үсгийн хэмжээ 12 нэгж, мөр хоорондын зай 1.5

Эш татах загвар:

1. Ерөнхий санаагаар эшлэх бол зохиогч (он) гэсэн байдлаар бичнэ. Жишээ нь: Ш.Лувсанвандан (1959) орчин цагийн монгол хэлний аялгууг аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу гэж гурав хуваасан байна.

2. Шууд эш татахдаа

- Хэрэв зохиогчийг өгүүлбэрийн эхэнд дурдвал Зохиогч “эшлэл” (он:хуудас) гэсэн загвараар бичнэ. Жишээлбэл: Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэл, аялгууг ангилахад тэдгээр хэл, аялгуугаар хэлэлцэгч ард түмний өнгөрсөн түүх, ялангуяа одоо үеийн нь бодит байдлыг анхаарахгүй байж үл болно” (1959:17) хэмээн тэмдэглэжээ. Мөн эшлэлд зохиогчийн эрдмийн зэрэг цол, эрхэлдэг ажил мэргэжлийн нэр (Академич, Их эрдэмтэн, Доктор, Профессор, Зохиолч, Дуун хөрвүүлэгч гэх мэт)-ийг тодотголыг хэрэглэх шаардлагагүй.
- Хэрэв 40-өөс дээш үгтэй эшлэл авбал ард нь зохиогч, он:хуудас гэж бичнэ. Жишээ нь: “Орчин цагийн монгол хэл, аялгууг ангилахад тэдгээр хэл, аялгуугаар хэлэлцэгч ард түмний өнгөрсөн түүх, ялангуяа одоо үеийн нь бодит байдлыг анхаарахгүй байж үл болох нь мэдээж хэрэг юм. Гэвч алив үндэстний нийгэм, улс төрийн хувиран өөрчлөгдөх нь түүний хэл, аялгууны хувиран өөрчлөгдөхөөс түргэн гэдгийг мартаж үл болно. Үүнээс гадна хэл, аялгуу бол хүмүүсийн харилцахын хэрэглүүр болох учир уул

хэл, аялгуугаар хэлэлцэгч ард түмний нийгэм, улс төрийн янз бүрийн нөхцөл байдлын дотроос эдийн засаг, соёл, улс төрийн харилцаа нь тэдний хэл, аялгуунд хамгийн чухал холбогдох учиртай ажээ. Өөрөөр хэлбэл, аль нэгэн ястан, үндэстний төвлөрсөн улс төр задравч хэрэв тэд улс төр, соёл эдийн засгийн талаар байнгын холбоотой байвал тэдний хэл, аялгуу заавал задарч, тус тусдаа биеэ даасан төрөл хэл болон хөгжих албагүй юм" (Лувсанвандан, 1959:17-18) гэдгийг судлаачид тэмдэглэсээр иржээ.

- 2 зохиогчтой бүтээлээс эшилбэл зохиогчдын нэрийг хоёулыг нь бичээд эш татсан бүтээлийн хэвлэгдсэн оныг ард нь бичнэ. Жиш: Ц. Дамдинсүрэн, Ш. Лувсанвандан нар (1942) толь бичигтээ... гэх мэт.
- 2-оос дээш зохиогчтой бүтээлээс эш татахдаа хамгийн эхний эшлэлд бүх зохиогчийн нэрийг бичээд дахиж эш татахдаа зөвхөн эхний зохиогчийн нэрийг бичээд олон тоо заах "нар" сул үгийг бичнэ. Мөн 2-оос дээш зохиогчтой бүтээлийн нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч, хамтран зохиогчийн аль нь болохыг дурдана.
- Ижил зохиогчтой нэг ижил онд хэвлэгдсэн бүтээлүүдийг үсгээр ялгана. Жиш: (Дамдинсүрэн, 1957а), (Дамдинсүрэн, 1957б).
- Нэг удаад олон бүтээлийг эшлэлд тэмдэглэхдээ цэгтэй таслалаар зааглана (Лувсанвандан, 1959; 1962; Ринчен, 1964).

Номзүйн загвар

Ном:

- 1 зохиогчтой бол - Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Бүтээлийн нэр. Хэвлэсэн хот., Хэвлэлийн газар, нийт хуудасны тоо. Жиш: Лувсанвандан Ш. 1959. Монгол хэл аялгууны учир. Уб., ШУДБХХ. 40 х.
- 2 ба түүнээс дээш зохиогчтой бол - Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор., Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор г.м. Бүтээлийн нэр. Хэвлэсэн хот., Хэвлэлийн газар, нийт хуудасны тоо.

Өгүүлэл:

- 1 зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. хэвлэсэн он. *Өгүүллийн нэр* (налуу үсгээр бичнэ). Сэтгүүлийн нэр, дугаар, тухайн өгүүлэл хэвлэгдсэн хуудасны дугаар.
- 2 ба түүнээс дээш зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор., хоёрдугаар зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. хэвлэсэн он. *Өгүүллийн нэр*. Сэтгүүлийн нэр, дугаар, тухайн өгүүлэл хэвлэгдсэн хуудасны дугаар.
- Өгүүллийн цахим хувилбарыг ашигласан тохиолдолд дээрх загварын дагуу бичээд цахим хаягийг ард нь хавсаргана. *Өгүүллийн нэр*. Сэтгүүлийн нэр, дугаар, тухайн өгүүлэл хэвлэгдсэн хуудасны дугаар. <http://monlingo.mn/12.06.5.16.2018/articles/lu1959.pdf>

Монгол бичиг болон хятад, япон, солонгос зэрэг бичиг үсгээрх бүтээлийг латин галигаар хөрвүүлж [] хаалтад монгол хэлээр орчуулж бичнэ үү.

Орчин цагийн монгол хэлний зөв бичих зүйн дүрмийг чанд баримталж бичнэ үү.

Жич. Эшлэлд тэмдэглээгүй бүтээлийг ном зүйд оруулахгүй.

Өгүүллийг жил бүрийн 9-р сарын 15-ыг хүртэл хүлээн авна. Тухайн өгүүлэл хэвлэн нийтлэх техник шаардлагад нийцсэн тохиолдолд өгүүллийг редакцын зөвлөлд шилжүүлнэ. Ерөнхий болон өргөтгөсөн редакцын зөвлөл ирүүлсэн өгүүллийг мэргэжлийн түвшинд хянан магадалж, сэтгүүлд хэвлэхээр зөвшөөрсөн эсэхийг 11-р сарын 15-аас өмнө зохиогчид цахим шуудан (e-mail)-аар мэдэгдэнэ.